5.2 Төлбөрийг тооцооны сараар авах ба энэ хугацаа нь хуанлийн сартай тэнцүү байна.

5.3 "Нийлүүлэгч" нь "Хэрэглэгч"-ийн үйлчилгээний нэхэмжлэлийг тухайн сарын 10-ны өдрийн дотор гэрээнд заагдсан и-мэйл хаягаар илгээнэ. "Хэрэглэгч"-ийн төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтны нэр, и-мэйл хаяг, утасны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд "Нийлүүлэгч" талд албан бичгээр мэдэгдэнэ.

5.4 "Хэрэглэгч" нь сарын үйлчилгээний төлбөрийг "Нийлүүлэгч"-ийн нэхэмжлэхийн дагуу тухайн сарын 20-ны өдрийн дотор төлнө. Нэхэмжилсэн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Нийлүүлэгч" ажлын 3 хоногийн дотор сануулга өгөх ба үүний дараа ажлын 5 хоногийн дотор төлбөр хийгдээгүй бол үйлчилгээг түр зогсоох эрхтэй.

5.5 "Хэрэглэгч" нь хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд 0.3 хувийн алданги төлнө.

5.6 Тухайн сард гарсан гэмтэл, саатлын нийт хугацааг техникийн дүгнэлтийн үндсэн дээр акт үйлдэн тогтоож, үйлчилгээ тасалдсан хугацааны төлбөрийг ирэх сарын хураамжаас хасаж тооцно. Гэмтлийн актанд тухайн саатал гарсан шалтгаан, авсан арга хэмжээ, үргэлжилсэн нийт хугацаа болон үйлчилгээний төлбөрөөс хасч тооцох хугацаа зэргийг тодорхой заах өгнө. Гуравдагч этгээдээс хамаарч үйлчилгээ доголдсон тохиолдолд хариуцлагыг "НИЙЛҮҮЛЭГЧ" хүлээхгүй.

5.7 "Захиалагч" нь хавсралтын "Үнэ тариф" хэсэгт заасны дагуу нэхэмжилсэн төлбөрийг заасан банкны дансанд шилжүүлнэ.

## Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Энэ гэрээнд заагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсад дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.

6.2 Гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэх ба боломжгүй болсон тохиолдолд хуулийн байгууллагад хандана.

6.3 Гэрээг хэрэгжүүлэх явцад байгалийн гамшиг, дайн. хориг арга хэмжээ буюу түүнтэй адилтгах давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээс хамаарсан гэмтэл, саатлын хариуцлагыг нийлүүлэгч хариуцахгүй.

## Долоо. Хугацаа

7.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаанд үйлчилнэ.

7.2 Энэхүү гэрээ болон гэрээний хавсралтуудад Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

7.3 Энэхүү гэрээний 7.1-д заасан хугацаа дуусгавар болоход талуудын аль нэг нь гэрээг дуусгавар болгох саналаа бичгээр гаргаагүй тохиолдолд энэхүү гэрээг дахин нэг жилээр сунгагдсанд тооцно.

**Талуудын албан ёсны хаяг, бусад өгөгдлүүд:**

| | | |
|---|---|---|
| Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар<br>"Хангарди" ордон 7 давхар 704 тоот<br>Утас: 330844 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар<br><br>Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр, 7 давхар, 707 тоот<br>Утас: 312785 | "Комтел" ХХК<br>БГД 1-р хороо 48-1 тоот<br><br>Утас: 93115151<br>21250005,21250008, |
| И-мэйл хаяг:<br>info@it.ub.gov.mn | И-мэйл хаяг:<br>it@sport.ub.gov.mn | И-мэйл хаяг:<br>info@comtel.mn |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| "ЗАХИАЛАГЧ"-ийг төлөөлж | "ХЭРЭГЛЭГЧ"-ийг төлөөлж | "НИЙЛҮҮЛЭГЧ"-ийг төлөөлж: |
|---|---|---|
| ............................................<br>/гарын үсэг/ | ............................................<br>/гарын үсэг/ | ............................................<br>/гарын үсэг/ |
| Н.Пүрэв, НЦХМТГ-ын Мэдээллийн аюулгүй байдал эрсдэл хариуцсан ахлах мэргэжилтэн | Н.Өлзийжаргал Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн | Б.Ариунцэцэг "Комтел" ХХК гүйцэтгэх захирал |

***210601 - Багаж хэрэгсэл худалдан авах***

## 2024 ОНЫ БАГАЖ ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ ТӨСВИЙН ТӨСӨЛ

*/төгрөгөөр/*

| № | Зориулалт | Материалын нэр | Шаардлагатай тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Албан хэрэгцээнд | Компьютер | 5 | 3,600,000 | 18,000,000 | шинээр нэмэгдэх албан хаагчдад шаардлагатай байгаа мөн сүүлийн жилүүдэд хөрөнгө худалдаж аваагүй тул албан хэрэгцээнд зайлшгүй шаардлагтай |
| 2 | Албан хэрэгцээнд | Принтер | 5 | 680,000 | 3,400,000 | |
| | | | | НИЙТ ҮНЭ | 21,400,000 | |

***210602 - Тавилга***

## 2023 ОНЫ ТАВИЛГА АВАХ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ

*/төгрөгөөр/*

| № | Зориулалт | Материалын нэр | Шаардлагатай тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Албан хэрэгцээнд | Бичиг хэргийн жижиг шүүгээ | 16 | 350,000 | 5,600,000 | шинээр нэмэгдэх албан хаагчдад шаардлагатай байгаа мөн сүүлийн жилүүдэд хөрөнгө худалдаж аваагүй тул албан хэрэгцээнд зайлшгүй шаардлагтай |
| 2 | Албан хэрэгцээнд | Бичгийн ширээ | 16 | 550,000 | 8,800,000 | |
| 3 | Албан хэрэгцээнд | Дугуйтай сандал | 8 | 250,000 | 2,000,000 | |
| 4 | Албан хэрэгцээнд | Цаас устгагч | 1 | 250,000 | 250,000 | |
| | | | | НИЙТ ҮНЭ | 16,650,000 | |

Төсөв хянасан дарга: ....................................../Ж.Ганболд/

Тооцоо гаргасан ня-бо: ................................/П.Ариунцэцэг/

9022011233
9077448 CBT17685

***210406 - бага үнэтэй түргэн элэгдэх зүйл***

2024 онд шаардагдах бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авах зардлын задаргаа

/төгрөгөөр/

| № | Зардлын төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ | ***Тайлбар*** |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Уртасгагч | ш | 10 | 30,000 | 300,000 | Албан хэрэгцээнд шаардлагатай уртасгагч авах |
| 2 | гар мауз | ш | 16 | 65,000 | 1,040,000 | Албан хэрэгцээнд шаардлагатай гар мауз |
| 3 | үдэгч | ш | 2 | 250,000 | 500,000 | Албан хэрэгцээнд шаардлагатай баримт үдэгч |
| 4 | усны шүүлтүүр | ш | 4 | 80,000 | 320,000 | Ус цэвэршүүлэгч филтер солих /улирал бүр/ |
| 5 | Гэрэл | ш | 60 | 15,000 | 900,000 | Конторын гэрэл солих |
| 6 | Чийг дулаан хэмжигч | ш | 1 | 45,000 | 45,000 | |
| 7 | Агаар чийгшүүлэгч | ш | 1 | 450,000 | 450,000 | |
| 8 | Архивын галын хэрэгсэл/ багц/ | ш | 1 | 1,200,000 | 1,200,000 | |
| **4** | **Нийт зардал** | | | | **4,755,000** | |

Төсөв хянасан дарга: ........................................./Ж.Ганболд/

Тооцоо гаргасан ня-бо: ................................/П.Ариунцэцэг/

Нийслэлийн БТСГ-ын 2024 онд шаардагдах Тээвэр шатахууны зардал

/төгрөгөөр/

| д/д | Зардлын нэр | Тоо хэмжээ | Нэг км-ийн үнэ | Нэг сарын дундаж км | Нэг сарын дундаж зардал | Жилийн тээврийн зардал | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Газрын даргын машины шатахуун | 1 | 880 | 840 | 739,200.0 | 8,870,400.0 | Нэг сард ногдох км, үнийг Нийслэлийн засаг даргын захирамж, авто базын тогтоосон тарифаар тооцов |
| 2 | Ажлын албаны машины шатахууны зардал | 1 | 880 | 500 | 440,000.0 | 5,280,000.0 | Уралдаан тэмцээнтэй үед тэмцээнд шаардлагатай хэрэгсэл ачих зөөвөрлөх шаардлага тулгардаг тул авто баазын дуудлагын тээврээс үйлчилгээ авдаг болно. /Авто баазын км-н тарифаар тооцов/ |
| **Нийт** | | | | | | **14,150,400.0** | |

Төсөв хянасан дарга: ......................................../Ж.Ганболд/

Тооцоо гаргасан ня-бо: ............................../П.Ариунцэцэг /

***210902 - Хичээл үйлдвэрлэлийн дадлага***

## Нийслэлийн БТСГ-н 2024 оны хичээл үйлдвэрлэлийн дадлагын тооцоо /80101-210902/

*/төгрөгөөр/*

| № | Сургалт, дадлагын нэр | Сургалт, дадлагад хамрагдах ажиллагсдын тоо | Нэгжийн үнэ | Нийт дүн | Тайлбар, үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Улс, нийслэлээс зохион байгуулсан төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтуудад ажилтнуудаа хамруулах | 16 | 200,000 | 3,200,000 | Нэг албан хаагчыг жилд 1 удаа хамруулах сургалтын төлбөрийг хүн тус бүрийг 200,000₮-р тооцов /16*200,000/ |
| 2 | Байгууллагын албан хаагчдыг монгол бичгийн багц сургалтад хамрагдах | 16 | 200,000 | 3,200,000 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолоор монгол бичгийг заавал эзэмших, ажилдаа ашиглах шаардлагатай. |
| 3 | Байгууллагын албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх дунд болон богино хугацааны сургалтад хамруулах | 3 | 1,620,000 | 4,860,000 | Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 зорилтын 4.3 дах заалт, |
| 4 | Архив албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн сургалтад хамрагдах | 1 | 250,000 | 250,000 | Жилд 1 удаа зохион байгуулалдаг архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт |
| | **Бүгд** | | **450,000** | **3,450,000** | |

***210901 - Бараа үйлчилгээний бусад зардал***

## 2024 ОНД ШААРДАГДАХ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ

*/төгрөгөөр/*

| № | Зориулалт | Зардлын нэр | Шаардлагатай тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Албан хэрэгцээнд | Бусад бараа үйлчилгээний зардал | 50 | 5,000 | 250,000 | Коггорт баллонтой цэвэр ус сард 4 ширхэг жилд 50 ширхэгээр тооцсон |
| 2 | Албан хэрэгцээнд | Ариутгалын зардал | 4 | 300,000 | 1,200,000 | Улиралд 1 удаа, жилд 4 удаа байхаар тооцов |
| 3 | Албан хэрэгцээнд | Бусад бараа үйлчилгээний зардал | 4 | 200,000 | 800,000 | Ажилчдын ахуйн жижиг материалын зардлууд багтсан болно /Улиралд 1 удаа хангалт хийх/ |
| 4 | Албан хэрэгцээнд | Принтер, компьютер тоног төхөөрөмжийн засвар | 16 | 100,000 | 1,600,000 | Албан хаагчдын албан хэрэгцээний компьютер тоног төхөөрөмжийн засварт шаардлагатай |
| 5 | Албан хэрэгцээнд | Цахилгаан монтаж, кабель, далдлагч жижиг засвар | 1 | 500,000 | 500,000 | Албан хаагчдын албан хэрэгцээний компьютер тоног төхөөрөмжийн засварт шаардлагатай |
| | | | | НИЙТ ҮНЭ | 4,350,000 | |

Төсөв хянасан дарга: ....................................../Ж.Ганболд/

Тооцоо гаргасан ня-бо: ................................../П.Ариунцэцэг/

**МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 11.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгдсэн зохицуулалтаар хангахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай:

1.1. Монгол хэлний үгийн санг баяжуулах, үндэсний сан хөмрөг бий болгох, цахим хэл шинжлэлийн салбарыг хөгжүүлэх, монгол хэлний нутгийн аялгуу, угсаатны цөөнхийн хэл, дохионы хэл, брайл бичгийн хэрэглээний өнөөгийн байдлыг судалж аман болон бичгийн хэл, дохионы хэлэнд суралцах арга зүйгээр хангах, холбогдох мэргэжилтэн бэлтгэх;

1.2. англи үгийг монгол хэлнээ хөрвүүлэх стандартыг боловсруулан эрх бүхий холбогдох байгууллагаар батлуулж мөрдүүлэх, гадаад нэр томьёог орчуулах, шинэ нэр томьёог оноох ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн бүтцэд нэр томьёоны судлалын асуудал хариуцсан нэгж байгуулах шаардлагатай эсэхийг судалж саналаа танилцуулах;

1.3. Монгол хэлний түвшин тогтоох стандарт шалгалтын механизм бүрдүүлэх;

1.4. Баян-Өлгий аймгийн монгол хэл бичгийн сургалтын чанарыг сайжруулах, багш нарын чадварыг дээшлүүлэх, Монгол-Казах, Монгол-Тува хэлний мэргэжлийн багш бэлтгэх, сургалтын гарын авлагаар хангах.

2. Гадаад улсад монгол судлал, түүний дотор монгол хэл бичгийн судлалыг хөгжүүлж, сурталчлан таниулах, тэнд амьдарч байгаа Монголчуудад зориулсан монгол хэлний сургалтыг дэмжиж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт даалгасугай.

3. Айл өрх бүр угийн бичгийг монгол бичгээр хөтлөхөд дэмжлэг үзүүлэх, гадаад улс оронд байгаа монголын түүх, соёлд холбогдох бичгийн дурсгалыг бүртгэх, хуулбарлан авах, сурталчлах, чулуун дээрх бичиг, соёлын өвийг хамгаалах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

4. Төрийн албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөхөд шаардлагатай холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг 2022 онд багтаан баталж, мөрдүүлэх талаар зохих арга хэмжээ авахыг Архивын ерөнхий газар (С.Энхбаатар), Стандарт, хэмжил зүйн газар (Б.Билгүүн)-т тус тус даалгасугай.

5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:

5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;

5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;

5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;

5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;

5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.

6. Үндэсний монгол бичгийн зөв бичих дүрмийн толийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, хэлэлцүүлэн батлуулж, мөрдүүлэх, холбогдох байгууллагатай хамтран үндэсний бичгийн "Юникод" стандартыг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл (С.Дулам)-д зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.ЭНХ-АМГАЛАН

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2023. 07. 20 № 03/4513

танай _______________-ны № _______________-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл ирүүлснийг хүргүүлж байна.

Харьяалах нутаг дэвсгэр, байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ И.БААТАРХҮҮ

1110203892

МОНГОЛ УЛСЫН
ХЭЛНИЙ БОДЛОГЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

14200, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
А.Амарын гудамж - 2, Соёлын төв өргөө 404 тоот
Утас: 261727 www.khelniizuvlul.mn
E-mail: helniizuvlul@gmail.com

2023.07.06 № 99

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
Д. СУМЪЯАБАЗАР ТАНАА

Монгол бичгийн үндэсний
хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай

Монгол хэлний тухай хуулийн 24.2-т 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хөтөлнө гэсэн заалттай.

Уг заалтыг хэрэгжүүлэх, бэлтгэл ажлыг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ үү. Үүнд:

1. Хэлний бодлогын үндэсний зөвлөл Архивын ерөнхий газартай хамтран Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдлийн байрлалд тавих үндсэн шаардлага, MNS 6395:2022 стандартыг боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газар баталж, нийтээр мөрдөж буй. Уг стандартын дагуу хэвлэмэл хуудсыг турших эхлэх, туршсан ажлын үр дүнг заасан хугацаанд тогтмол ирүүлэх;

2. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны даргын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн А/38 тоот тушаалаар баталсан "Төрийн албан хаагчдад зориулсан монгол бичгийн сургалтын хөтөлбөр"-ийн дагуу Нийслэлийн бүх төрийн байгууллагуудад монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтыг 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн тасралтгүй явуулах;

3. Дээрх үйл ажиллагааг дүүрэг, хорооны хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн 9 дүүргийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл болгох;

Албан бичгийн хэвлэмэл хуудас туршсан, сургалт явуулсан талаарх мэдээллийг нийслэл, дүүргээр нэгтгэн гаргаж, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанд 2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Хэвлэмэл хуудас, сургалтын хөтөлбөр, хичээл заах багштай холбоотой мэдээллийг Ажлын албаны 261727 утсаар лавлаж болно.

Төрийн албан хаагчдад зориулсан монгол бичгийн сургалтын хөтөлбөрийг хавсаргав.

Хавсралт: 6 хуудастай.

ДАРГА Н.НАРАНГЭРЭЛ

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн
Ажлын албаны даргын 2022 оны 09 дүгээр
сарын 22-ны өдрийн А/38 тоот тушаалын
хавсралт

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН МОНГОЛ БИЧГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

**Хөтөлбөрийн үндэслэл:**

"Монгол хэлний тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 1.2-т "Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх", 7 дугаар зүйлийн 7.2-т "Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна", мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө"; "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 1 дүгээр зүйлийн 1.6-д "Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн"; Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-ийн 1 дүгээр зүйлийн 3-т "Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвшинэ", Монгол Улсын Засгийн газраас байгуулсан "Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хороо"-ны 2021-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.2.8 дахь заалтын "Төрийн жинхэнэ албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн сургалт, төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад монгол бичгийн хичээлийг нэмж тусгах асуудлыг судлан шийдвэрлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 144 дүгээр захирамж, 2022 оны 01 дүгээр сарын 05-ы өдрийн "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 07 тоот тогтоол, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/26 тоот тушаал, түүний хавсралтыг үндэслэн, энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

**Хөтөлбөрийн зорилго:**

Төрийн албан хаагчдыг монгол бичигт сургах, монгол бичгээр баримт бичиг төлөвлөх, боловсруулах, албан хэрэг хөтлөх, цахим орчинд хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

**Хөтөлбөрийн зорилт:**

1. Монгол бичигт үе шаттай сургах
2. Монгол бичгээр баримт бичиг төлөвлөх, боловсруулах арга зүйг эзэмшүүлэх
3. Монгол бичгээр албан хэрэг хөтлөх чадварт дадуулах
4. Монгол бичгийн цахим хэрэглээнд хэвшүүлэх

**Хөтөлбөрийн хамрах хүрээ:** Монгол Улсын бүх шатны байгууллагын төрийн албан хаагчид

**Хөтөлбөрийн хүрэх үр дүн:**

| Түвшин | Мэдлэг | Чадвар | Хандлага |
|---|---|---|---|
| **Нэгдүгээр түвшин** | 1. Үндсэн зурлага, эгшиг ба гийгүүлэгч үсэг<br>2. Бичмэл, дармал тигийн ялгаа<br>3. Эгшиг зохицох ёс<br>4. Дэвсгэрлэх ёс | 1. Үсэг, үеийг унших, бичих<br>2. Залгавар бүтээврийг таньж унших<br>3. Үг, холбоо үгийг унших, бичих<br>4. Өгүүлбэрийг цахимаар болон гараар бичих<br>5. Бичмэл, дармал бичил эх унших | 1. Монгол Улсын иргэн хүний хувьд үндэсний хэл соёл, бичиг үсгээ сурах журамт үүрэгтэйгээ мэдэх<br>2. Төрийн албан хаагч хүний хувьд монгол бичгээ зайлшгүй сурч эзэмших шаардлагатайг ойлгох |
| **Хоёрдугаар түвшин** | 1. Язгуур, үндсийн төгсгөл, түүний хувилах ёс<br>2. Дагавар, нөхцөлийн хэлбэрүүд, тэдгээрийг холбон бичих дүрэм | 1. Нэр, үйл үгийг зөв бичих<br>2. Утга ялган унших, бичих<br>3. Бичлэг, дуудлагын зөрөөтэй үгсийг унших, бичих<br>4. Бичил эхийг цахимаар болон гараар бичих | 1. Монгол бичгийг гүнзгийрүүлэн сурч, хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй болох |
| **Гуравдугаар түвшин** | 1. Монгол бичгийн зөв бичих дүрэм<br>2. Оноосон нэр бичих зарчим<br>3. Гадаад үг бичих зарчим<br>4. Монгол бичгийн цахим хэрэглээ | 1. Монгол бичгийн хөрвүүлэг хийх<br>2. Оноосон нэрийг зөв бичих<br>3. Гадаад үгийг зөв унших, бичих<br>4. Монгол бичгээр цахимаар бичих<br>5. Монгол бичгээр албан баримт бичиг боловсруулах | 1. Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах хандлагатай болох |

**Хөтөлбөрийн агуулга:**

| № | Судлах агуулга | |
|---|---|---|
| | **Унших агуулга** | **Бичих агуулга** |
| **Нэгдүгээр түвшин** | - Үсэг, үеийг зөв унших<br>- Залгавар бүтээврийг зөв унших<br>- Монгол тоог мэдэх<br>- Мэргэжлийн үг хэллэг, нэр томьёог зөв унших, хөрвүүлэх<br>- Мэргэжлийн агуулга бүхий бичил эхийг уншаад, утгыг тайлбарлах, хөрвүүлэх | - Үсгийн эхэн, дунд, адагт орох хэлбэрийг зөв бичих<br>- Үсгийг амилуулан үе бүтээж бичих<br>- Мэргэжлийн үг хэллэг, нэр томьёог зөв бичих<br>- Дармал өгүүлбэрийг бичмэлээр бичих<br>- Цахимаар бичих |
| **Хоёрдугаар түвшин** | - Дуудлага, бичлэг зөрөөтэй үгсийг унших, хөрвүүлэх<br>- Мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо, гадаад үг унших<br>- Гадаад үг бүхий, мэргэжлийн холбогдолтой өгүүлбэрийг уншаад тайлбарлах, хөрвүүлэх<br>- Албан бичгийн эхийг уншаад, утгыг тайлбарлах, кирилл бичигт хөрвүүлэх | - Залгавар бүтээврийг зөв бичих<br>- Дүрс ялган зөв бичих<br>- Гадаад үг бичих<br>- Монгол бичгээр өгүүлбэр бичих<br>- Тэмдэглэл, өргөдөл зэрэг бичил эхийг монгол бичгээр бичих<br>- Цахимаар бичих |
| **Гуравдугаар түвшин** | - Мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо, гадаад үг унших<br>- Өгүүлбэрээс зөв бичих дүрмийн алдааг хянаж унших<br>- Эхийн найруулгыг хянаж унших | - Оноосон нэрийг зөв бичих<br>- Гадаад үг бичих<br>- Цахимаар өгүүлбэр бичих<br>- Албан бичгийн эхийг монгол бичгээр боловсруулах |

**Арга зүй:**

**Нэгдүгээр түвшин**

Уншуулж сургах арга зүй

- Унших чадварыг хөгжүүлэх агуулга 70%-аас багагүй байх шаардлагатай. Нэгдүгээр түвшинд саадгүй унших, уншсанаа ойлгодог болгохыг чухалчилна.
- Минутад 30-аас доошгүй үг уншдаг болгоно.
- Орчин цагийн дуудлагаар буюу галиглуулахгүй уншуулахад анхаарна.
- Харьцуулан жишиж, зүй тогтлыг ойлгуулах арга зүйг чухалчилна.
- Нүдлэн тогтоолгох ажиллагааг голчилж, дасгалын олон хэлбэрийг ашиглана.

Бичүүлж сургах арга зүй

- Бичих чадварыг хөгжүүлэх агуулга 30%-аас ихгүй байх шаардлагатай. Нэгдүгээр түвшинд зөв бичих чадварыг чухалчлахгүй.
- Дармалаас хуулж, хичээнгүй бичих чадварыг хөгжүүлнэ.
- Галиглаж хэлснийг монгол бичгээр бичиж чаддаг болгоно.
- Орчин цагийн дуудлагаар хэлснийг монгол бичгээр бичих чадварыг хөгжүүлнэ.

**Хоёрдугаар түвшин**

Уншуулж сургах арга зүй

- Унших чадварыг хөгжүүлэх агуулга 40%-аас ихгүй байх шаардлагатай. Хоёрдугаар түвшинд монгол ба гадаад үг, бичлэг дуудлагын зөрөөтэй үгсийг саадгүй унших, уншсанаа ойлгодог болгохыг чухалчилна.
- Минутад 60-аас доошгүй үг уншдаг болгоно.
- Орчин цагийн дуудлагаар буюу галиглуулахгүй уншуулахад анхаарна.
- Харьцуулан жишиж, зүй тогтлыг ойлгуулах арга зүйг чухалчилна.
- Нүдлэн тогтоолгох ажиллагааг голчилж, дасгалын олон хэлбэрийг ашиглана.

Бичүүлж сургах арга зүй

- Бичих чадварыг хөгжүүлэх агуулга 60%-аас багагүй байх шаардлагатай. Хоёрдугаар түвшинд зөв бичих чадварыг чухалчилна.
- Гадаад нэр томьёо, улс орон, газар усны нэр, албан байгууллага, хүний нэрийг саадгүй уншдаг, бичдэг болгоход анхаарна.
- Хөрвүүлж бичих эхийн үгийн тоог хязгаарлахгүй. Хурлын товч тэмдэглэл, өргөдөл байж болно.
- Хөрвүүлгийг толь бичиг ашиглан хийнэ.

**Гуравдугаар түвшин**

Уншуулж сургах арга зүй

- Унших чадварыг хөгжүүлэх агуулга 30%-аас ихгүй байх шаардлагатай. Гуравдугаар түвшинд өгүүлбэр ба эхийг унших хурдыг нэмэгдүүлэх, зөв бичих дүрэм болон найруулгын алдааг олж чаддаг, засаж залруулах чадварыг нь хөгжүүлэхэд анхаарна.
- Минутад 100-аас доошгүй үг уншдаг болгоно.
- Харьцуулан жишиж, зүй тогтлыг ойлгуулах арга зүйг чухалчилна.
- Нүдлэн тогтоолгох ажиллагааг голчилж, дасгалын олон хэлбэрийг ашиглана.

Бичүүлж сургах арга зүй

- Бичих чадварыг хөгжүүлэх агуулга 70%-аас багагүй байх шаардлагатай. Гуравдугаар түвшинд зөв бичих болон найруулан бичих чадварыг чухалчилна.
- Цахимаар бичих эхийн үгийн тоог хязгаарлахгүй.
- Хөрвүүлгийг толь бичиг ашиглан хийж болно.

**Бие даалтын ажил:**

1. Бие даалтын ажлыг суралцагчдын унших, бичих чадварыг хөгжүүлэхэд чиглүүлнэ.

2. Чөлөөт цагаараа, бие даан суралцах боломжийг хангахуйцаар боловсруулна.
3. Бие даалтын ажлыг онлайн орчинд байршуулах ба хүртээмжтэй байхад анхаарна.
4. Бие даалтын ажлыг дасгал даалгаврын олон хэлбэр ашиглаж, бүтээлчээр суралцах үйлийг дэмжсэн байдлаар боловсруулна.

**Орчин:**

Сургалтын орчин нь бие даан болон хамтран суралцах боломжтой, суралцагчдын танин мэдэх хэрэгцээг хангасан, хүртээмжтэй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, сурах хүсэл тэмүүллийг төрүүлэхүйц байна.

**Хэрэглэгдэхүүн:**

1. Энэхүү хөтөлбөрийн дагуу зохиосон нэг, хоёр, гуравдугаар түвшний сурах бичиг, цахим сурах бичиг тус хөтөлбөрийн сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болно.
2. Хөтөлбөрийн агуулгыг эзэмшүүлэх багшийн номыг сургагч багш нар сургалтын арга зүйн үндсэн хэрэглэгдэхүүн болгож ашиглана.
3. Мөн тус хөтөлбөрийн агуулгад нийцсэн бусад ном, гарын авлага, сургалтын материал, үзүүлэн, цахим хэрэглэгдэхүүнийг нэмэлтээр ашиглаж болно. Тухайлбал: Монгол Улсын Үндсэн хууль, www.president.mn, "Төрийн мэдээлэл" сэтгүүл, "Хүмүүн бичиг" сонин зэргийг цахим хэрэглэгдэхүүн болгож, сургалтад ашиглах боломжтой.

**Үнэлгээ:**

1. Үнэлгээг бодитой бөгөөд нээлттэй хийнэ.
2. Суралцагчдын унших, бичих чадварыг сургалтын тухайн түвшний агуулга, зорилготой уялдуулан үнэлнэ.
3. Үнэлгээг орц, явц, гарц гэсэн дараалаар хийх ба энэ нь сургалтын үр дүнг тодорхойлох үндсэн баримт болно.

-----------------oOo---------------

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

# ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## I ХЭСЭГ

## ТӨРИЙН АЛБА

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**23 дугаар зүйл.Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага**

23.1.Төрийн улс төрийн болон тусгай албан тушаалд тавих тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно.

23.2.Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно:

23.2.1.тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх;

*/Энэ заалтад 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

*/Энэ заалтад 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

23.2.2.эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх;

*/Энэ заалтад 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

*/Энэ заалтад 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

23.2.3.ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.

*/Энэ заалтад 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

*/Энэ заалтад 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*

23.3.Энэ хуулийн 11.1-д заасан албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцож болно.

*/Энэ хэсгийг 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./*

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан хугацааг төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамаарах албан тушаалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

*/Энэ хэсгийг 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./*

23.5.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батална.

*/Энэ хэсгийн дугаарт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

23.6.Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.

*/Энэ хэсгийн дугаарт болон хэсэгт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

23.7.Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.5-д заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.

*/Энэ хэсгийн дугаарт болон хэсэгт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

23.8.Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн $10^1$.4 дэх хэсэгт заасан арга хэмжээг авна.

*/Энэ хэсгийн дугаарт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

**24 дүгээр зүйл.Мэргэшүүлэх багц сургалт**

24.1.Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална.

24.2.Мэргэшүүлэх багц сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОХ ЖУРАМ

**25 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд томилох нийтлэг журам**

25.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.

**26 дугаар зүйл.Төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгуур**

26.1.Төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно.

26.2.Энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг болон 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан тохиолдолд мөн хуулийн 26.1-д заасан шалгуурыг хангасанд тооцно.

26.3.Энэ хуулийн 23.2-т заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно.

26.4.Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газрын саналыг харгалзан төрийн албаны төв байгууллага батална. Албан тушаалд шатлан дэвшүүлж томилоход энэ журмыг баримтална.

**27 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилох**

27.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

27.1.1.төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон энэ хуулийн 16.1-д заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс;

*/Энэ заалтад 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

27.1.2.төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас;

*/Энэ заалтад 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

27.1.3.төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс;

~~27.1.4.энэ хуулийн 27.1.3-т заасны дагуу нөхөх боломжгүй бол нээлттэй сонгон шалгаруулалт зарлах.~~

*/Энэ заалтыг 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*

27.2.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

27.3.Энэ хуулийн 27.1-д заасан тохиолдолд томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагаас санал болгосон нэр дэвшигчийг холбогдох албан тушаалд томилно. Томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагын санал болгосон төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшигчийг томилохоос хуульд заасан үндэслэлээр нэг удаа татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд төрийн албаны төв байгууллага өөр хүнийг зохих журмын дагуу санал болгоно.

**28 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд томилох хугацаа**

28.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд томилохдоо тодорхой хугацаа заахгүй.

28.2.Хуульд хугацаатай томилохоор заасан төрийн албан тушаалд нөхөн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх албан тушаалтны бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

28.3.Төрийн жинхэнэ албанд анх орсон иргэнд туршилтын хугацааг 6-12 сар хүртэл хугацаагаар тогтоож болно.

28.4.Төрийн жинхэнэ албан тушаалд ажилласан туршилтын хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно.

28.5.Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журмыг төрийн албаны төв байгууллага батална.

**29 дүгээр зүйл.Албан тушаалын ажлын байрны сургалт**

29.1.Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тодорхойлно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан хугацааг төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамаарах албан тушаалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.
*/Энэ хэсгийг 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./*
23.5.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батална.
*/Энэ хэсгийн дугаарт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*
23.6.Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.
*/Энэ хэсгийн дугаарт болон хэсэгт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*
23.7.Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.5-д заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.
*/Энэ хэсгийн дугаарт болон хэсэгт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*
23.8.Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн $10^{1}$.4 дэх хэсэгт заасан арга хэмжээг авна.
*/Энэ хэсгийн дугаарт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

**24 дүгээр зүйл.Мэргэшүүлэх багц сургалт**

24.1.Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална.
24.2.Мэргэшүүлэх багц сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОХ ЖУРАМ

**25 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд томилох нийтлэг журам**

25.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.

**26 дугаар зүйл.Төрийн захиргааны албан тушаалд томилох үндсэн шалгуур**

26.1.Төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно.
26.2.Энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг болон 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан тохиолдолд мөн хуулийн 26.1-д заасан шалгуурыг хангасанд тооцно.
26.3.Энэ хуулийн 23.2-т заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно.
26.4.Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газрын саналыг харгалзан төрийн албаны төв байгууллага батална. Албан тушаалд шатлан дэвшүүлж томилоход энэ журмыг баримтална.

**27 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилох**

27.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

